



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/462

Чингис хот

Иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэхэд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 4 дүгээр зүйлийн 4.1.8, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Иргэдийн оролцоот шинэ Хэнтий" төслийн хүрээнд иргэдийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ажлын танилцуулга бэлтгэн, хэвлүүлэхэд зориулж 9.600.000 /есөн сая зургаан зуун мянган/ төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010731